

2024 оны 4 сарын 25-ны өдөр

№2024/01

Улаанбаатар хот

Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн
тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, Компанийн дүрмийн 7
дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурлын Тооллогын комиссын 02 дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Ард Кредит ББСБ” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн
талаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 21 тогтоолоор
гаргасан дүгнэлтийг хүлээн зөвшөөрч баталсугай.


ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ

Компанийн дүрэмд нэмэлт,
өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 30 дугаар зүйлийн 30.5 дахь хэсэг, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.4.1, 7 дугаар зүйлийн 7.6, 7.9 дэх хэсэг, болон 2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 03 тоот тогтоолыг дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах өөрчлөлтийг оруулсугай.
 - 1.1. Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт “Компани нь Хүчтэй.Хамтдаа. гэсэн уриа үгтэй байх бөгөөд компанийн бэлгэдэл тэмдэг нь  КРЕДИТ ББСБ байх ба АРД гэсэн улаан гурван үсгээс бүрдсэн байх ба хажууд нь Кредит ББСБ гэж бичсэн байна” гэж;
 - 1.2. Компанийн дүрмийн 4.2 дахь хэсэгт “Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчдийн хариуцлагыг хүлээхгүй мөн хувьцаа эзэмшигчид нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд гагцхүү өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээнэ” гэж;
 - 1.3. Компанийн дүрмийн 4.4 дэх хэсэгт “Компанийн эрх бүхий албан тушаалтан нь Монгол Улсын Компанийн тухай хуульд заасан хариуцлага хүлээнэ.” гэж;
 - 1.4. Компанийн дүрмийн 6.1 дэх хэсэгт “Компанийн нэг бүр нь 10 (арав) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 364,000,000 (гурван зуун жаран дөрвөн сая) ширхэг хувьцаатай байна.” гэж;
 - 1.5. Компанийн дүрмийн 6.2 дахь хэсэгт “Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь 3,640,000,000 (гурван тэрбум зургаан дөч сая) төгрөг байх ба гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувьцаа эзэмшигчдийн худалдан авч эзэмшсэн нийт хувьцааны нэрлэсэн үнийн дүнгээс хувь нийлүүлсэн хөрөнгө бүрдэнэ.” гэж тус тус өөрчлөх;
2. Ард Кредит ББСБ ХК-ийн Компанийн дүрэмд дараах нэмэлтийг оруулсугай.
 - 2.1. Компанийн дүрмийн 1.5 дахь хэсэгт “Компани нь хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, харилцагч, үйлчлүүлэгч, ажилтнуудаа урамшуулах зорилгоор өөрсдийн урамшууллын оноо АрдКойныг ашиглана. Энэ нь бусад хэлбэрээр урамшуулал олгохыг хориглох заалт болохгүй” гэж;
 - 2.2. Компанийн дүрмийн 2.1 дэх хэсэгт “Компани нь Хөрөнгө Оруулагч Үндэстэнг цогцлоох эрхэм зорилготой ажиллана” гэж;
 - 2.3. Компанийн дүрмийн 2.2 дахь хэсэгт “Салбарын хөгжлийг түүчээлэгч” алсын

хараатай ажиллана” гэж;

3. Энэхүү шийдвэрийн 1, 2 дахь хэсэгт заасан нэмэлт, өөрчлөлт оруулсан Компанийн дүрмийг хавсралтаар баталсугай.
4. Энэхүү шийдвэрийн хавсралтаар баталсан Компанийн дүрмийг хууль, тогтоомжийн дагуу улсын бүртгэлд бүртгүүлэх, холбогдох бусад байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал /Г.Сүхбаатар/-т даалгасугай.
5. Энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавихыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ч.Ганзориг/-т даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ГАНЗОРИГ